

Р.Дарьхүү
Б.Энхээ

Доктор (Ph.D) МУИС-ийн багш
ХИДС-ийн багш, магистр

ЁС СУРТАХУУНЫ ХАРИУЦЛАГЫН АСУУДАЛД

Түлхүүр үг: хүн, эрх чөлөө, сонголт, субъект, объект

Товч утга: Энэхүү өгүүлэлд ёс суртахууны хариуцлага, эрх үүргийн харилцан хамаарал, орчин үед ёс суртахууны хариуцлагыг дээшлүүлэх арга замын асуудлыг авч үзэв.

Эрх зүй, социологи, нийгмийн шинжлэх ухаанууд хариуцлагын тухай асуудлыг янз бүрээр өөр өөрийн судлах зүйлийн хүрээнд тайлбарладаг. Хариуцлага нь нийгмийн үнэт зүйл бөгөөд хүний үйлдэл бүхэн хариуцлага шаарддаг. Хариуцлагатай байх нь сайн үйл нэр төрийн хэрэг юм. Орчин үед нийгмийн хөгжил хүнээс улам ч хариуцлага шаардаж байна. Учир нь хүн бол нийгмийн дээд үнэт зүйл бөгөөд хүний үнэ цэнэ, нийгэмд эзлэх байр суурь, ажлын амжилт, үр дүнг дээшлүүлдэг нэг гол хүчин зүйл нь хариуцлага юм. Хариуцлага нь хүний өөрийн үйлдэл хийх арга, чадвар, бололцооны асуудлыг өөртөө багтаадаг.

Ёс суртахууны хариуцлагын асуудлыг судлах нь түүнийг тодорхойлохоос эхэлбэл зохих боловч, тийм тодорхойлолт боловсруулах нь нэлээд нарийн төвөгтэй ажил юм. Энэ хариуцлага гэж чухам юу болохыг ердийн ухамсрын төвшинд хүн бүр мэднэ. Хариуцлагыг хийсэн бол хариуц гэсэн энгийн томъёололоор илэрхийлж болно. Хариуцлагын тухай шинжлэх ухааны тодорхойлолт гаргах гэж оролдоход энэ ойлголт туйлын олон утгатай нь илэрнэ. Ёс суртахууны хариуцлага нь нийгмийн гишүүддээ ёс суртахууны зарчим, хэм хэмжээ болгон тавьж буй нийгмийн шаардлага нөгөө талаас хувь хүний өөртөө тавих шаардлага, ухаалаг байдал, үүргээ биелүүлэх бусдад нөлөөлөх чадвар юм.

Ёс суртахууны хариуцлага, түүнийг бие хүнд төлөвшүүлэх, хүмүүжүүлэх асуудлыг сурган хүмүүжүүлэх ухаан судалдаг. Ёс суртахууны хариуцлагын тодорхой агуулгыг, аль нэгэн ард түмэн түүхийн аль нэгэн үедээ хэрхэн сэтгэж, ямар байдалтай байсныг түүхийн шинжлэх ухаан судална. Энэ бүх талыг ёс зүй ямар нэгэн хэмжээгээр харгалзан үзэж боловсруулдаг. Гэвч ёс зүй нь хариуцлагын өвөрмөц-ёс суртахууны талыг дан зан суртахууны агуулгаар нь буюу зан төлөвийн төлөө хүлээх хариуцлага тухайн нийгэмд хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны үнэт зүйлтэй тохирч байгаа эсэх талаас нь тодруулан ялгадаг онцлогтой.

Хариуцлага гэдэг нэр томъёо нь /латин хэлний *respondere*-хариулах, хариуцах гэсэн үгнээс гаралтай/ XV зууны хоёрдахь хагасын хууль зүйд анх хэрэглэгдсэн ойлголт бөгөөд буруутай хүн хариу хэлэх, хариуцах ёстой гэсэн утгатай байв. Мөн XVIII зууны II

хагаст Давид Юм, Иммануила Кант нарын бүтээлд энэхүү ойлголт тусгагджээ. XIX зууны үед Ф.Ницше "Би хүсч байна", "Би хийж байна" гэдгийг нэгтгэгч хүсэл зоригийн шинжийг хэрэгжүүлэхэд хариуцлага хэрэгтэй гэдэг утгаар авч үзсэн буй.

Аливаа хариуцлага нь хүмүүсийн хамтын ажиллагаа, харилцааны явцад төлөвшдөг бөгөөд тухайн хүний үйл ажиллагаа, эд юмс, хүмүүст хандах хандлагыг илэрхийлэн хамгаалдаг тогтвортой шинж, даруу төлөв байдал, шийдэмгий зорилт, шаргуу зэрэг зан төлөвийн шинжүүд, мөн ажлын амжилт үр дүн зэргээр илэрдэг.

Ер нь хариуцлага бол хүмүүс өмнөө тавьсан зорилт, тодорхой шаардлагыг ухамсартайгаар биелүүлэх мэдлэг, арга туршлага, ёс суртахууны зөв сонголт хийх чадвар, тодорхой үр дүнд хүрэх чадвар, түүнчлэн тэдгээр асуудалтай холбогдуулан, хүний зөв буруу, түүний үйл хэргийг сайшаах буюу муучлах, шагнах буюу шийтгэх явдал юм.

Хариуцлага гэж юу вэ? Гэсэн асуудлаар орчин үед улам ч олон талаас нь авч үзэх болжээ. Тухайлбал, философич Герберт Фингарит "On Responsibility" (Хариуцлагын тухай. 1967) зохиолдоо хувь хүний хариуцлагаа ухамсарлах хийгээд түүнийгээ хэрэгжүүлэх нийгмийн бүтэц хоёрын хооронд тодорхой, зохиоцолдоо, хамаарал байдгийг авч үзжээ. Энд нэг талаас хувь хүний хариуцлага нь нийгмийн хөгжил дэвшлийн чухал нөхцөл болдог, нөгөө талаас нийгмийн бүтэц нь хариуцлагын тогтолцоог сайжруулдаг болохыг онцолжээ мөн Вильфред Кантвелл Смит хариуцлагын тухай өгүүлэлдээ "хүний амьдралын тулгуур үнэн болох ёс суртахууны хариуцлага нь үнэнд анхны алхам бөгөөд сүсэг бишрэл, сайн үйл, цэлмэг ухаан зэрэг нь дараах алхам хийхэд хүнд тусална" хэмээн бичжээ. Эндээс үзвэл ёс суртахууны хариуцлага нь нийгмийн бусад төрлийн хариуцлагын үндэс болдог байна. Түүнчлэн Ханс Ионасын үзлээр "Хариуцлагын нэг дэх гол шаардлага бол хүн ертөнцөд үйлдлээрээ нөлөөлөх чадвар, хоёрт үйлдлээ хянах чадвар, гуравт үр дүнг нь тодорхой хүрээнд урьдчилан харах чадвар юм". Хариуцлага нь бүх нөхцөл байдлыг тал бүрээс нь ухамсарлан тооцох явдал юм. Үүний үр дүнд ажил хэрэг амжилттай байдаг. Хариуцлагатай байна гэдэг нь ухаалаг, ажил хэрэгч, үүргээ хэрэгжүүлэх, анхаарлаа төвлөрүүлэх чадвартай шууд холбоотой.

Хариуцлагын ёс зүйн сонгодог баримтлал нь бие хүн өөрийн үйлдлийн үр дагаврыг өөрөө хариуцах ёстой гэсэн баримтлал юм. Бие хүн нь бие даасан, чөлөөт байдалтай байдаг бөгөөд бүхнийг дийлэх оюун ухаантай, бас өөрийн шалтаг, шалтгааны шинжийг тогтоох чадвартай юм. Бие хүний амьдрал, үйл ажиллагаанд байгаль, нийгэм гэдэг хоёр ертөнц сөргөлдөж байдаг. Тэдгээрийн зөрчлийг хүн оюуны хүчирхэг чадвараар шийдвэрлэдэг. Үүнд: байгаль бол ээдрээтэй нарийн, механик бүхэл, нийгэм нь априор /Кантын хэлснээр/,

эсвэл хэлцлийн /Гоббс, Ж.Ж.Руссогийн хэлснээр/ шинжтэй хуулиудад захирагддаг хэмээн үзэж иржээ.

Германы гүн ухаантан И.Кантын үзлээр, хүн бол уг чанараараа хоёрдмол шинжтэй. Нэг талаас хүн өөрийн мэдрэхүй, хүсэл тэмүүллээрээ байгалийн бусад амьтдын нэгэн адил байгалийн зайлшгүй хуульд захирагддаг. Нөгөө талаас хүн бол ёс суртахуунлаг, ухаантай амьтан учраас "өөртөө байгаа юмыг" ухаарсан тийм ертөнцөд хамаарагдана. Энэ утгаараа хүн бол эрх чөлөөт амьтан мөн. Ёс суртахууны хууль нь нөхцөл шалтгаангүй айлдал буюу хатуу баримтлал юм. Энэ хуулиар хувь хүн бүхний хувийн амьдралдаа мөрдөх дүрэм журам нь нийт хүмүүсийн мөрдөх дүрэм журам байх ёстой. Бодит амьдралд ёс суртахууны хууль, эрх хоёр зохицдоггүй. Энэхүү зохицол нь үзэгдлийн ертөнцөд биш, харин ухаарсан ертөнцөд л боломжтой. Эрх чөлөө, үүрэг, хариуцлага нь ухаарсан ертөнц мөн. Категорик императив нь ёс суртахууныг ямар нэгэн гадаад зорилгын тулд биш, харин үүрэг хариуцлагын үүднээс тавьдаг гэжээ.

Мөн түүнчлэн хүн бол нэгэн зэрэг ноумен ба феномен гэж И.Кант ойлгож байв. Хүн нь феномены хувьд бүгд хоорондоо харилцан холбогдож, харилцан хамаарч байдаг байгалийн хуулиудад захирагдана. Харин хүн ноумены хувьд туйлын чөлөөтэй бөгөөд түүний үйл ажиллагаа, үйлдэл нь байгалийн хуулиудад үл захирагдан зөвхөн оюун ухааны хуулиудыг дагана. Хүн оюун ухаанлаг учраас сонголт хийх чадвартай, иймээс эрх чөлөөтэй. Ийнхүү хүн гэдэг нь феномены хувьд байгалийн жам ёсны зайлшгүй чанарт захирагдаж, "өөртөө буй юм"-ын хувьд чөлөөт байдлын эх уурхай болон илрэх хоёрдмол шинжтэй амьд бие мөн гэж И.Кант үзжээ. Ийнхүү эрх чөлөөтэй байна гэдэг нь хүн үйлдэл болгоныхоо, сонголт болгоныхоо төлөө хариуцлага хүлээх явдал юм. Энэхүү үзэл нь шинэ утга агуулга, тайлбараар баяжигдан хожим экзистенциалист философийн үндсэн асуудлын нэг болж тавигдсан юм.

XX зуунд хариуцлагын ёс зүйн сонгодог бус баримтлал бий болжээ. Энэ баримтлалын хөгжилд герменевтикчид, франкфуртын сургуультаан, аналитик философичд ихээхэн хувь нэмрээ оруулжээ. Тухайлбал, Хайдеггер, Гадамер нарын герменевтикт ёс суртахууны хариуцлагын асуудлыг сонирхолтой авч үзсэн. Герменевтик бол ертөнц дэх ахуйн тухай сургаалын нэгэн хувилбар юм. Практик хариулт өгвөл зохих асуултыг хүнд ертөнц тавьдаг. Ертөнц дэх хүний ахуй нь хүний хариуцлагад үндэслэнэ. Ёс зүйн герменевтик хувилбарыг хөгжүүлэхийг оролдоход хариуцлагын ёс зүйд хүрэх юм.

ХХ зууны хариуцлагын ёс зүй нь сонгодог баримтлалаас зарим талаар татгалзсан. Хариуцлагын сонгодог бус баримтлалд хүмүүсийн ашиг сонирхлыг зохицуулах тухай, хувийн болон нийгмийн зүйлийн харьцааны тухай асуудал илүү онцгой шинжтэй. Хүний багтан орсон санамсаргүй, магадтай, тодорхой бус харьцааны уг чанарыг харгалзан үзэх шаардлагатай холбогдон олон асуудал тулгарна. Өөр нэг зүйл бол хариуцлагын ёс зүйн хэрэгжилт, шинжлэх ухаан, техник, эдийн засаг, улс төрийн алхааг гүйцэхгүй байгаа нь анхаарал татаж байна.

Хариуцлагыг хувь хүний өөрийн өмнө хүлээх хариуцлага, хамт олны өмнө хүлээх хариуцлага, нийгмийн өмнө хүлээх хариуцлага, миний өмнөөс бусдын хүлээх хариуцлага гэж ангилж болох юм.

Ёс суртахууны хариуцлага хэмээх категори нь бие хүнд тавьж буй ёс суртахууны тодорхой шаардлагыг биелүүлэхийн үүднээс түүний байгаль, нийгэмд болон өөртөө хандах харилцааг тодорхойлно. Хэрэв бие хүний ёс суртахууны үүрэг нь ёс суртахууны шаардлагыг ухаарах, өөрийн байгаа байдалд хэрэглэх, хэрэгжүүлэхэд оршдог бол энэ зорилго ямар хэмжээгээр биелж байгаа буюу эсвэл түүнийг биелүүлээгүйн учир ямар хэмжээгээр буруутай байгаа тухай асуудал бол ёс суртахууны хариуцлагын тухай асуудал юм. Ингэхлээр ёс суртахууны хариуцлага бол бие хүний ёс суртахууны үйл ажиллагаа түүний үүрэгтэй тохирч байгаа байдал гэж үзэж болно. Хүн тавьж буй шаардлагыг биелүүлж чадах эсэх, түүнийг хэдий хэмжээгээр зөв ойлгож вэ, түүний үйл ажиллагааны чадвар хэдий өргөн хүрээтэй вэ, шаардагдаж буй үр дүнд хүрэх эсэхийг хүн хариуцах уу, энэ бүхэн хариуцлагын асуудалд багтана. Философичид гадаад нөхцөл байдлын нөлөөг харгалзахгүйгээр хүнийг үйл ажлын үр дүнд бүхэлд нь буруутгаж, эсвэл хүн үүргээ буруугаар ойлгож байгааг зөвтгөж байсан юм¹.

Цааш нь, бие хүн хэний өмнө, юуны төлөө хариуцлага хүлээдэг вэ? гэсэн асуулт зайлшгүй тулгардаг. Энэ талаар янз бүрийн үзэл баримтлал бий. Тухайлбал, зарим судлаачид бие хүн гол нь бусдын өмнө хариуцлага хүлээдэг гэж нотолдог. Бид өөртэйгээ адил бусад хүмүүстэй харилцаж амьдардаг. Энэ харилцаа холбоо бол бидний амьдралын нэн чухал нөхцөл юм. Иймд хүний эрх чөлөө нь туйлын буюу үнэмлэхүй байж чадахгүй, тэр нь бусад хүний ашиг сонирхол, зориг хүсэл, түүний байж байгаагаар хязгаарлагдсан байдаг. Бусад хүмүүс бидний эрх чөлөөг хязгаарлагч төдийгүй бас бид харилцан үйлчлэгч, хамтдаа зорилго тавигч, хүлээх үүргээ хуваалцагч байдаг бөгөөд харилцан үүрэг, хариуцлага хүлээдэг.

¹ "Словарь по этике" М., 1989 г, стр 70

Бид бусад хүмүүсээс нийгэм-соёлын болон сэтгэл зүйн талаар бодитой хараат байдал дээр бидний бусдын өмнө хүлээх ёс суртахууны хариуцлага тулгуурлана. Энэ хараат байдал жам ёсны учраас түүнд ямар ч сөрөг утга байхгүй.

Эл асуудлаарх өөр нэг үзэл баримтлал нь хүн юуны өмнө бурханы өмнө хариуцлага хүлээдэг тухай шашны үзэл юм. Тэрхүү үзлээр хүмүүс хоёрдогч, Бурхан анхдагч бөгөөд ёс суртахууны хууль тогтоогч, эцсийн шүүгч, иймд бид зөвхөн түүний өмнө хариуцлага хүлээнэ.

Бас нэг өөр үзэл баримтлал нь бусдад баримжаалахыг бодгальч үзлийн зарчимтай хослуулахыг эрмэлзсэн сургаал юм (Э.Фромм, В.Франкл г.м). Энэ тохиолдолд хүн өөрийн нинжин сэтгэлийн өмнө хариуцлага хүлээдэг ба гадны ямар ч зааварт захирагдахгүй. Гэвч түүний нинжин сэтгэл нь зөвхөн хувийн сайн сайханд төдийгүй бас бусад хүмүүсийн сайн сайханд баримжаалсан (чиглэсэн) байна.

Цаашилбал, хариуцлагатай холбоо бүхий өөр нэг асуулт нь: "Бид юуны төлөө, үйлдлийнхээ, бодлынхоо, мэдрэмжийнхээ, эсвэл энэ бүхнийхээ төлөө хариуцлага хүлээдэг үү?" гэсэн асуулт юм. Бусдын өмнө хүлээх хариуцлагыг гол болгодог иргэний гэх үзэл нь бид юуны өмнө үйлдлээ хариуцдаг гэж баталдаг. Мөн энэ зарчим дээр хууль зүйн хариуцлага тулгуурлана. Хэрэв хүн хэн нэгэнд хор хүргэе гэж бодоод бодитойгоор юу ч хийгээгүй бол хариуцлага хүлээхгүй. Бодож, боловсруулсан бөгөөд хэрэгжүүлсэн үйлдлийг санамсаргүй үйлдсэнээс илүү хатуу шийтгэдэг боловч бодлын төлөө хууль ёсоор шийтгэж болохгүй юм. Хариуцлагын талаарх иргэний гэх хандлага нь сэтгэл санааны байдлын төлөө хариуцлагыг үгүйсгэхгүй боловч эн тэргүүнд үйлдлийн хариуцлагыг тавьдаг.

Үүнээс бие хүний хариуцлагын талаарх шашны ёс суртахууны үзэл огт өөр юм. Иргэний ч, шашны ч үзлийн үүднээс гэсэн бодол, мэдрэмж нь зан төлөвийн шугамыг тодорхойлдог бөгөөд иймд ёс суртахууны хариуцлага нь хуулийн хариуцлагаас өргөн утгатай юм. Учир нь бид өөрийн бие хүнлэг чанарын бүхэл байдлыг түүний сэтгэл санаа болон зан төлөвийн талаар нэгдмэл байлгахыг хариуцна.

Бид өөрсдийн үйлдлийн цаашдын үр дагаврыг хариуцах уу? Бид түүнийг урьдчилан харж чадах хэмжээгээр л хариуцна. Хүний үйл ажлаас үр дүн гарахад зөвхөн тавьсан зорилт, хүчтэй зориг хүсэл, арга хэрэгслийн нөөц цөм оролцох төдийгүй бас олон тооны хөндлөнгийн нөлөө оролцдог юм. Зорилтыг материаллаг хэлбэртэй болгоход тэр болгон урьдчилан харж болохгүй шинж, байдал бий болдог. Хүмүүсийн зан төлөв, харилцан холбооны тухай, нийгмийн үйл

явцын эцсийн дүн магадтай хүчин зүйлийн тухай ярихад үр дүнгийн тодорхой бусын төвшин эрс нэмэгдэнэ.

Мөн түүнчлэн асуултыг “би зөвхөн өөрийгөө хариуцах уу? эсвэл дэлхий дахиныг хариуцах уу?” гэж тавих нь нэн чухал юм. Хүн юуны өмнө өөрийгөө, бусад хүмүүст хандах өөрийн харилцааг, үүргээ биелүүлсэн чанарыг хариуцна. Хэрэв түүний үүрэгт бусдыг удирдах, жолоодох, эсвэл хүмүүжүүлэх ажил ордог бол энэ утгаараа бас бусдыг хариуцна.

Түүнээс гадна, бусдыг хариуцаж болохгүй. Бусад нь эрх чөлөөтэй, өөрийн шийдвэр гаргах чадвартай хэн ч байлаа гэсэн бусдын сэтгэл санаа, шийдвэрийг хариуцна гэдэг бол Эзэн бурханаас дээш гарна гэсэн эрмэлзэл юм. Тэгэхлээр бие хүний ёс суртахууны хариуцлагыг ярихад гарцаагүй ёс суртахууны автономийн тухай асуудал хөндөгдөн тавигдана.

Дээрхийн гэгээн XIV Далай лам “Шинэ мянганы хүмүүн төрөлхтний ёс зүй” гэдэг номондоо бүх нийтийн хариуцлагын талаар тодорхой өгүүлсэн нь бий. Тэрээр онцлон өгүүлэхдээ: “Бусдын сайн сайхны төлөө тавьж буй халамжийн хөрсөн дээр бид бүх нийтийн хариуцлагын мэдрэхүйг өөртөө хөгжүүлэх ёстой авч бидний хэн нэг нь, жишээ нь дайн болон өлсгөлөнг хариуцахгүй бизээ. Буддын сургаалд зааснаар бид бүх дэлхийн амьд амьтны тусын тулд зүтгэх үүрэгтэй...”

Бүх нийтийн хариуцлагын мэдрэхүйг хөгжүүлэх нь багагүй ач тустай бөгөөд ингэснээр бид өөрсдийн ойр дотны хүмүүсээс гадна бусдын асуудлыг хүлээж авахад нэн дөхөмтэй болох ажгуу. Чингэвэл бид бусдаас илүү зовж байгаа хүмүүсийг халамжлах зайлшгүй шаардлагатай гэдгийг ойлгож эхэлдэг....

Бодит байдлыг ийнхүү авч үзэхэд ёс зүй болон энгийн зайлшгүй нь бид бүхнээс нэг л зүйлийг шаардаж байна. Бусдын хэрэгцээ хийгээд эрхийг үл хүндлэх явдлыг даван туулахын тулд эцсийн бүлэгт бид бүгд л адилхан л хүн шүү дээ гэсэн зүйлийг өөртөө байнга сануулж байх хэрэгтэй¹ гэжээ.

Эндээс үзвэл Дээрхийн Гэгээн Далай ламын үзлээр бид бүгд хувиа хичээсэн, хэн нэгний зовлон шаналалыг бидэнд хамаагүй мэтээр ойлгож хүлээн авдаг. Гэтэл бид бусдын бий болгосон хайр халамжин дээр л амьдардаг. Өөрөөр хэлбэл, бусдаас бидэнд өгсөн хайр халамжийг мэдэрч чадсанаар би хэн ч байлаа гэсэн бусадтай л адил хүн. Тиймээс бусдад тохиолдож буй уй гашуу, өлсгөлөн гуйланчлалыг өөрт тохиолдсонтой адилаар хүлээн авч чаддаг байх ёстой. Ингэж бид бусдын төлөө тавьсан бидний хайр халамжийн нөлөө нь

¹ Далай лам “Шинэ мянганы хүмүүн төрөлхтний ёс зүй” УБ., 2001 он 142-143 дахь тал

бидний ёс суртахууны хариуцлагын мэдрэхүйг зөвхөн өөртөө хөгжүүлээд зогсохгүй бусдын сайн сайхны төлөө бидний зүрх сэтгэл цохилно гэсэн үг юм.

Ийнхүү хариуцлага нь хүмүүсийн бүх төрлийн тэмүүлэл, сайн үйлс хийгээд энэрэнгүй байдлын чадварыг багтаадаг бөлгөө. Хэрвээ бид, энэ бүхнийг бусдын төлөө хийж байна хэмээн бодож ажиллавал үр дүнд нь нийгмээрээ л хождог. Хэрэв бусдын сайн сайхан болон мэдрэхүйн төлөө санаа үл тавих тохиолдолд бидний үйл ажиллагаа өөр чиглэлтэй болно. Хүний үндсэн мэдрэхүйн дутагдлаас болж шашин, улс төр, эдийн засаг хийгээд бусад нь бохирдож хүмүүн төрөлхтний төлөө зүтгэхийн оронд түүнийг мөхөлд хүргэж болно. Тиймээс бүх нийтийн хариуцлагын мэдрэхүйг төлөвшүүлэхийн дээр бид бүхэн үнэн сэтгэлээсээ хариуцлагатай болох шаардлагатай ажгуу. Хэрвээ бид өөрийн зарчмыг амьдрал дээр хэрэгжүүлэхгүй бол тэд зөвхөн хоосон үг болон агаарт замхрах болно. Жишээлбэл, улс төрчид маш хариуцлагатай, шударга үйл хэрэгтээ үнэнч явах шаардлагатай. Ажил хэрэгч хүн бол өөрийн эрхэлж буй ажил бүрт бусдын хэрэгцээг тооцох нь нэн чухал билээ. Хуульч хүн бол мэргэжлийн боловсролоо шударга үнэний төлөө тэмцэхэд хэрэглэх нь чухал ажгуу.

Учир нь хүн нийгэмд тодорхой мэдлэг боловсрол эзэмшсэн байна гэдэг нь өөртөө төдийгүй бусдын өмнө хариуцлага хүлээх чадвартай болдог бөгөөд мэргэжлийн онцлогоос шалтгаалан зарим тохиолдолд хэсэг бүлэг хүнээс гадна ард түмэн, тив, бүс нутгийн хэмжээнд ч хариуцлага хүлээх явдал байдаг.

Энэ талаар Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди "Монгол суртал" өгүүлэлдээ: "Эцэг эх, ургийн нэр төрийг хамгаалах нь мах цусны тасархай элгэн садныхаа өмнө хүлээх хариуцлага мөн... Өөрийн нэр төрийг хамгаалах, үүний тулд нөхрийнхөө нэр төрийг хамгаалах нь монгол араншингийн чухал дэнс юм байна. Нэр хугарахаар яс хугар гэж товч хэрнээ гүн агуулгаар илэрхийлдэг байжээ... Эрдэнэт хүнийг дээдлэх нь бидний суртахуун оршин ахуйн гол агуулга.Тэгэхлээр хотлоор нь хүн шиг болгохыг хичээх нь монгол суртлын зорилго мөн. "Чихэндээ нүгэлт үгийг бүү сонсьё хэмээн хичээгтүн. Нүдэндээ самуун өнгийг бүү үзье хэмээн хичээгтүн. Амандаа чалчаа шалигийг бүү өгүүлье хэмээн хичээгтүн. Санаандаа хортой сэтгэлийг бүү үүсгэе хэмээн хичээгтүн. Энэ дөрвөн зүйлийн хичээлийг хичээн чадваас хэдий бурхан эс боловч сайн хүн болох нь магад болой" гэж бичжээ¹. Энэ нь хүн өөрийн хариуцлагаа бүрэн ухамсарлаж, өдөр бүр үйл

¹ Н.Багабанди "Монгол ухаан" УБ.,2001 он. 6-7 дахь тал.

ажиллагаандаа хэрэгжүүлж чадснаар жинхэнэ хүн шиг амьдарч, аж төрж чадна гэдгийг өгүүлсэн хэрэг юм.

Ёс суртахуун бол хүн хүний нийгэмд өөрийгөө зохицуулж, үйлийн агуулга, хэм хэмжээг тогтоох оюун сэтгэлийн чанар юм. Ёс суртахуун нь хүний мөн чанараас урган гарч, түүнтэй хамт хувьсан өөрчлөгдөж байдаг. Хүний мөн чанар бол өөрийн нь оюун ухаан, үзэл, ёс суртахууны нэгдлээс үүсч, өөрийг нь жолоодож, хянах далд дүр юм. Ийм учраас хүний мөс чанар сэтгэлийн тогтвортой агуулга, илрэх хууль болж байдаг. Ариуссан сэтгэл амьдралыг хариуцлага гэж үзнэ. Ариуссан сэтгэл өөрийгөө оюун ухаанаар гэрэлтүүлэн гийгүүлж, амьдралын өнгөрсөн, одоо, ирээдүйг жамаар нь холбож утга агуулгаар дүүргэнэ.

Хүн ухаарлынхаа хэрээр ухаалаг хэрэглэж, чинээлэг амьдрах эрхтэй төдийгүй үүрэгтэй. Хүн төрөлхтний удмыг залгаж насыг туулах хариуцлага хүнээс зөвхөн өөрийн ахуй, сэтгэлийн хэрмэнд амьдрах бус өөртэйгээ адил төстэй "Би"-гийн дэргэд оршиж, хойч үедээ хүмүүнлэг харилцааны орчин нөхцөл үлдээх үүрэг ноогдуулна¹.

Ёс суртахууны хариуцлага нь өөрийн нөхцөл болон угтвар болгосон эрх чөлөөтэй шууд холбоотой. Энэ холбооноос ангид ёс суртахууны хариуцлагын тухай ярих нь утгагүй. Жишээлбэл, зан төлөвийн хэлбэрийг сонгон авах эрх чөлөө, бололцоо байхгүй бол, үйл ажиллагааны субъектэд ёс суртахууны хариуцлага хүлээлгэж болохгүй юм. Ёс суртахуунт бие хүн үйл ажлаас зөвхөн өөрөө мэдэж байсан бөгөөд хүссэн зүйлээ өөрийн гэж хүлээн зөвшөөрч, түүний төлөө хариуцлага хүлээх ёстой гэж үздэг болохыг Гегель тэмдэглэсэн нь бий. Ийнхүү ёс суртахууны хариуцлага бол нэг талаас, объектив, нийгмийн утга холбогдолтой, нөгөө талаас субъектив, бие хүний талуудын нэгдэл юм. Тэр хариуцлага нь өөрийн болон бусдын үйлдлийг сайн муу, шударга ба шударга бус, хүнлэг ба хүнлэг бусын тухай, ер нь зан суртахуунтай ба зан суртахуунгүй зүйлийн тухай хувийн төсөөллийн үүднээс үнэлдгээрээ субъектив талтай юм. Хариуцлага оноох, түүний хэмжээ ба шинж нь ямар нэгэн хэмжээгээр субъектив төсөөлөл, тогтоомжоор тодорхойлогдоно. Гэтэл ёс суртахууны хариуцлага нь бас объектив шинжтэй. Учир нь түүний агуулга, аль нэгэн хүний ухамсраас үл хамаарах нийгмийн харилцаагаар нөхцөлдсөн байдаг. Жишээлбэл, хариуцлагын хэмжээ нь бодгаль хүний зан төлөвийн нийгмийн утга холбогдлоос, улмаар түүний нийгмийн байдал, мэргэшил зэрэг үйл ажиллагааны янз бүрийн хүрээнд гүйцэтгэж буй нийгмийн үүргээс хамаарна. Ерөнхийдөө ёс суртахууны хариуцлагын

¹ Д.Бямбасүрэн "Орчлонгийн хүрд" УБ., 1994 он. 124-129 дэх тал.

объектив талыг түүний нийгмийн агуулга, субъектив талыг түүний бие хүний хэлбэр тус тус бүрдүүлнэ.

Ёс суртахууны хариуцлагын субъект нь хэн байж болох тухай асуудал, мөн юуны төлөө ёс суртахууны хариуцлага оноодог, эсвэл ёс суртахууны хариуцлагын объект нь юу болох тухай асуудал сонирхол татсан асуудал юм.

Үйл ажиллагааг нь зан суртахууны үүднээс ангилж болох бүхэн буюу бие хүн, хамт олон, эсвэл нийгмийн аль нэгэн нийтлэг (ард түмэн), эсвэл нийгэм бүхэлдээ түүнийг төлөөлсөн байгууллагууд ёс суртахууны хариуцлагын субъект болно. Үйл ажиллагааны илрэл, өөрөөр хэлбэл, бие хүний үйлдэл, зан авир, тэдгээрээр дамжин түүний ёс суртахууны чанар, эсвэл хамт олон, нийгэм дэх ёс суртахууны уур амьсгал нь ёс суртахууны хариуцлагын объект болно. Ийнхүү нийгэм бүхэлдээ болон түүний элемент бүхэн ёс суртахууны хариуцлагаар тодорхойлогдоно.

Ёс суртахууны хариуцлага нь ёс суртахууны нэгэн адил хүмүүсийн үйл ажиллагаа, зан төлөвт объектив "ахуй"-тай байна. Хариуцлагатай (эсвэл хариуцлагагүй) гэж үйл ажиллагааны аль нэгэн талыг нэрлэдэг бөгөөд үүний дараа л, үйлдэлтэй холбогдуулан ашиг сонирхлын илрэл, зорилго тавих, ёс суртахууны аль нэгэн үнэт зүйлд баримтлах зэрэг хүний ухамсрын аль нэгэн хөдөлгөөнийг ангилна. Ер нь эцсийн дүндээ, хүний нийгмийн оршин байхыг хадгалах, үргэлжлүүлэх, түүнийг дэвшүүлэн хөгжүүлэх хэрэгцээнд тохирсон зан төлөвийг хариуцлагатай зан төлөв гэнэ. Энэ хэрэгцээ бол объектив шинжтэй юм. Ёс суртахууны хариуцлагын объектив агуулга түүний бие хүний хэлбэрээс анхдагч ач холбогдолтой болох нь үүгээр тодорхойлогдоно. Оюун ухаант хүний хувьд бүх ертөнц тунгалаг. Ертөнцөд зайлшгүй ноёрхож байдаг, шалтгаан, үр дагаврын харилцан холбоонд оршдог оюун ухаан бол агуу зүйл. Ж.Милль хариуцлагыг шийтгэлтэй холбон тайлбарласан. Тэрээр "Ёс суртахууны хариуцлага гэж юу вэ? Хариуцлага бол шийтгэл" гэж хэлсэн байдаг.

ХХ зуунд хүний хариуцлагын үндсийг оюун ухаант чанараас гадна экзистенциаль тусгай чанартай холбон үзэх болов. Тухайлбал, Ж.П.Сартрын үзлээр, "Бид ямагт сонголтыг хийж байдаг. Түүний нэг бие даасан сонголт бол эрх чөлөө. Эрх чөлөө бол тохиолдлын сонголт биш. Хүн ямагт эрх чөлөөт хүн бөгөөд чөлөөт сонголтынхоо үрээр газар сайгүй саад тотгортой учирна. Сонголт бол хариуцлага. Эрх чөлөө нь хариуцлагаас ангид зүйл биш. Хүн ертөнцийг болон өөрийгөө хариуцдаг. Энэ бол түүний оршин ахуйн арга юм. Миний юм бүхэн надаар хийгдэнэ. Бид энэ ертөнцөд хаягдсан эхний агшнаасаа л өөрийгөө хариуцна, би эрх чөлөөтэй бөгөөд

хариуцлагатай. Энд ямар ч бурхан хариуцахгүй. Энэ бүхнээс үзвэл экзистанциалист философийн хувьд бие хүний хариуцлага нь түүний оршихуйн үндэс, чухал хүчин зүйл мөн.

Сүүлийн 20-оод жил хариуцлагын ёс зүй ихээхэн хөгжлөө. Хариуцлагыг нэн чухал үнэт зүйл гэж хүлээн зөвшөөрч байна. Яагаад ХХ зууны төгсгөлд хариуцлагын ёс зүй анхаарал татах болов гэхээр энэ зууны шинжлэх ухааны болон философийн үзэл баримтлалуудад харьцангуй /харьцааны/, түгээмэл хамаарлын /системт чанар ба нийтлэгийн/, мөн хүний халамжтай ирээдүйн интуиц давамгайлах болсонтой холбоотой.

Бие хүний ёс суртахууны хариуцлага нь тухайн хүн нийгмийн ба хувийн ашиг сонирхлыг хэрхэн зохицуулж хослуулж байгаа болон түүний хэр идэвхтэй, ажил хэрэгч байдлын илэрхийлэл юм. Бие хүний ёс суртахууны хариуцлага нь тухайн хүний ерөнхий мэдлэг, боловсрол, соёл, зан байдал зэргээс шууд хамаарна. Бие хүн нийгмийн нэг амьд эд эсийн хувьд түүний хариуцлага нийгэм, хамт олон, бусдын эрх ашгийг ямар нэгэн хэмжээгээр хөндөж, эерэг эсвэл сөрөг нөлөө үзүүлдэг. Өнөө үед бие хүний ёс суртахууны хариуцлагаас түүний эрх чөлөө болон ажил амьдрал ямар байх нь шууд хамаарах болов. Иймд хүн бүр улс төр, эрх зүйн хариуцлагаа дээшлүүлэх нэг нөхцөл нь ёс суртахууны хариуцлагыг өөртөө төлөвшүүлэх явдал мөн.

Бие хүний хамгийн үнэт чанар бол хариуцлага. Хэлж байгаа үг, хийж байгаа үйлдэл болгоныхоо төлөө хариуцлага хүлээдэг. Хүн байна гэдэг бусдын болон өөрийн өмнө хүлээх хариуцлагаа ухамсарлах явдал юм. Бие хүний зан суртахууны тэсвэр хатуужил, нягт нямбай, идэвх санаачлагатай байдлын үр дагавар нь хариуцлага мөн. Идэвх санаачлагагүй, хатуужил тэвчээргүй, салан задгай, залхуу хойрго хүн хэзээ ч хариуцлагатай байдаггүй. Ажлын зохион байгуулалт, дэг журам, хариуцлага сайн газар ажлын гүйцэтгэл, чанар, үр бүтээл илүү байдаг. Ялангуяа удирдах ажилтан, хуульч, эмч, багш зэрэг тодорхой мэргэжлийн хүмүүсийн ёс суртахууны хариуцлага нөлөө онцгой их байдаг.

Дүгнэлт.

Ёс суртахууны хариуцлага нь нийгмийн бусад төрлийн хариуцлагын үндэс суурь болдог. Ёс суртахууны хариуцлага нь хүн өөрийн ёс суртахууны үйлдэлээрээ бусдад нөлөөлөх чадвар мөн өөрийн үйлдлийг хянах чадвар, бас өөрийн үйлдэл үйл ажиллагааны үр дүнг тодорхой хүрээнд урьдчилан харах чадварыг хүнд төлөвшүүлдэг. Энэ хэмжээгээр хүмүүсийн ажил хэрэгч байдал, нийгэмд эзлэх байр суурь дээшилдэг байна.

Ном зүй:

1. Н.Багабанди "Монгол ухаан" УБ.,2001 он.
2. Д.Бямбасүрэн "Орчлонгийн хүрд" УБ.,1994 он.
3. Ц.Балхаажав "Хүн та хэн бэ?" УБ.,2001
4. А.А.Гусейнов "Этика" М.,1998
5. П.С.Гуревич "Философская антропология" М.,2001
6. Дээрхийн гэгээн XIV Далай лам Данзанжамц "Шинэ мянганы хүмүүн төрөлхтний ёс зүй" УБ.,2001
7. Е.В.Золотухина-Аболина "Современная этика" М.,2000
8. Сартр. Ж. Экзистенциализм-это гуманизм. Сумерки богов. М.,1989.
9. Д.Содномгомбо. Р.Дарьхүү. "Философи" УБ., 2004
10. Д.Тунгалаг "Ёс зүй" УБ.,2002
11. "Человек" /философско-энциклопедический словарь" М.,2000
12. Fingaret. H. On responsibility. NY. 1967.
13. Jonas. H. The Imperative of responsibility NY. 1984.